



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот


Жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын Зам, тээврийн хөгжлийн сайдын төсвийн XV.1.1.48-д заасан "Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км (Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум)" төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хавсралтаар баталсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж ажиллахыг Авто замын бодлого зохицуулалтын газар (Ч.Сугармаа), санхүүжилтийг баталсан дүнд багтаан санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Цэвэлмаа), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат)-т тус тус даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2024 оны 02 дугаар сарын 02 -ны
өдрийн 17/29 дугаар тушаалын хавсралт

Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/ төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажлын жагсаалт

(Төслийн код - УТ2402804408)

(сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	"Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/"-ын 1-р ээлжийн ПК0+000-ПК41+500 хоорондох 41.5 км авто замын ажил, ЦДАШ-ын ажил, Гадна холбооны ажил буюу Багц-1	2024	2026	46,019.0	5,500.0
2	"Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/"-ын 1-р ээлжийн ПК41+500-ПК83+000 хоорондох 41.5 км авто замын ажил, Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн авто замаас Дархан сум хүртэлх 2.616 км авто замын ажил буюу Багц-2	2024	2026	48,537.8	5,500.0
3	"Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/"-ын 2-р ээлжийн ПК83+000-ПК128+000 хоорондох 45 км авто замын ажил, Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн авто замаас Баянмөнх сум хүртэлхх 1.4 км авто замын ажил, Баянмөнх сум доторх 1.5 км авто замын ажил буюу Багц-3	2024	2026	47,411.9	5,500.0
4	"Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/"-ын 2-р ээлжийн ПК128+000-ПК174+053.468 хоорондох 46.05 км авто замын ажил буюу Багц-4	2024	2026	45,345.90	5,500.0
	НИЙТ ДҮН			187,314.6	22,000.0